



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/726

Булган сум

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор 16 сум, 1 тосгоны иргэдэд сургалт нөлөөллийн ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээр ажилд шаардлагатай 18,589,000 (арван найман сая таван зуун наян есөн мянга) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний ажлыг эрчимжүүлэх зорилгоор 16 сум, 1 тосгоны иргэдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 11-ны өдрийн А/З.О дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор
сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах ажлын удирдамж

Нэг.Нийтлэг үндэслэл:

"Байгаль орчныг хамгаалах тухай" хууль, "Ойн тухай" хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлиг үндэслэнэ.

Хоёр.Сургалт нөлөөллийн арга хэмжээний зорилго:

Орон нутгийн хэмжээнд ойн чиглэлээр хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхэд залуучууд, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх цөлжилт, элсний нүүдлийг тогтоон барих эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд мэдлэг, мэдээллийг түгээхэд оршино.

Гурав.Хамрах хүрээ:

Аймгийн хэмжээнд сум, баг, иргэн, аж ахуй нэгж, байгууллага оролцоно.

Дөрөв.Хэрэгжүүлэх хугацаа:

Сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулна.

Тав.Үйл ажиллагааны чиглэл:

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүн, малын амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэн бүр мод тарьж ногоон ирээдүйг бүтээх мэдлэгийг дээшлүүлнэ.

Зургаа.Үр дүн:

- "Байгаль орчныг хамгаалах тухай" хууль, "Ойн тухай" хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлиг "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлнэ.

- Орон нутгийн хэмжээнд ойн чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг чанартай гүйцэтгэх, байгууллага, аж ахуй нэгж, айл өрх бүр орчин тойрондоо модоо зөв сонгон ашигт модыг тарих мэдлэгтэй болно.

- Тарьц, суулгац ургуулдаг иргэн, аж ахуй нэгжтэй биечлэн уулзах хамтран ажиллах мэдээлэл солилцоно.

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 11 ны/ний өдрийн 326 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



Сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах хөтөлбөр


Сэдэв: "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

Хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд

Зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Сум дундын ойн анги, аж ахуй нэгжүүд

2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр		
Хугацаа	Сэдэв, чиглэл	Илтгэгч/хариуцагч
9:00-9:30	Сургалтад оролцогчдыг бүртгэх	
9:30-09:45	Сургалтын нээлт	БОГ-ын дарга А.Гантөмөр
9:45-10:20	Сумдын мод тарих газрын судалгааг танилцуулах (Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан талбай)	БОГ-ын ойн нэгжийн дарга Б.Отгонжаргал
10:20-11:00	Аймгийн хэмжээнд тарьц суулгацын нөөцийн мэдээлэл	БОГ-ын ойн нэгжийн дарга Б.Отгонжаргал
11:00-11:10	Цайны завсарлага	Анаг амралт
11:10-11:40	Тэрбум модны хэрэгжилт	БОГ-ын ойн нэгжийн дарга Б.Отгонжаргал
11:40-12:20	Хэлэлцүүлэг	
12:20-14:00	Өдрийн хоол	Анаг амралт
14:00-14:30	Ногоон байгууламжид тарих модны сонголт	ХАА-н МСҮТ-ийн ойжуулалт, үржүүлгийн багш Б.Наранбаатар
14:30-15:00	Айл, ерхийн хашаандаа тарих, модны төрөл сонголт хийх	Булган сум дундын ойн ангийн дарга Б.Алтансүх
15:00-15:20	Ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалт, таналт	ХАА-н МСҮТ-ийн ойжуулалт, үржүүлгийн багш Б.Наранбаатар
15:20-15:50	Мод бутнаас үр, мөчир бэлтгэх арга, технологи, хадгалалт, хамгаалалт	Булган сум дундын ойн ангийн дарга Б.Алтансүх
15:50-16:00	Цайны завсарлага	Анаг амралт
16:00-16:20	Хэлэлцүүлэг	
16:20-16:40	Жимсний мод, бутыг өвөлжүүлэх арга	ХАА-н МСҮТ-ийн ойжуулалт, үржүүлгийн багш Б.Наранбаатар
16:40-17:30	Тарьц, суулгацын нөөцтэй аж ахуй нэгжүүдийн танилцуулга	
17:30-18:30	Ахмад ойжуулагчийн туршлага	З.Баасансүрэн
19:00-19:40	Оройн хоол	Анаг амралт
2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр		
11:00-16:00	Волейболын тэмцээн	

Аймгийн Засаг дарга 2024 оны
дүгээр сарын 11-ний өдрийн А/ЗСГ дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт



Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор
сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зардал

Сургалтын зардал					
д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	Байр	хүн/хоног	50/1	65000	3 250 000
2	Өдрийн хоол	хүн/хоног	222/1	25000	5 550 000
3	Цайны завсарлага	ш	222/2	3500	1 554 000
4	Ойжуулалт, нөхөн сэргээлт, мод тарилтын мэдээллийн эмхэтгэл ном	ш	230	22500	5 175 000
Хэсгийн дүн					15 529 000
Тэмцээний зардал					
№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	Заал түрээс	Өдөр	1	350 000	350 000
2	Шүүгч	Хүн	2	110 000	220 000
3	Медаль	ш	54	15 000	810 000
4	Волейбол эрэгтэй (баг)	1 байр	8	300 000	300 000
		2 байр	8	200 000	200 000
		3 байр	8	100 000	100 000
5	Волейбол эмэгтэй (баг)	1 байр	8	300 000	300 000
		2 байр	8	200 000	200 000
		3 байр	8	100 000	100 000
6	Дартс эрэгтэй (ганцаарчилсан)	1 байр	1	100 000	100 000
		2 байр	1	80 000	80 000
		3 байр	1	60 000	60 000
7	Дартс эмэгтэй (ганцаарчилсан)	1 байр	1	100 000	100 000
		2 байр	1	80 000	80 000
		3 байр	1	60 000	60 000
Хэсгийн дүн					3 060 000
Нийт дүн					18 589 000